

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## 1. Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	10
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	11
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16
3.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.25 № 06/271  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгалийн түүхийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Байгалийн түүхийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Байгалийн түүхийн музейн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Байгалийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Н.Зоригтбаатарт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгалийн түүхийн музейн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгалийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “СМД аудит” ХХК-ийн аудитор Д.Гэндэнпэлжээ ахлагчтай аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Байгалийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “СМД аудит” ХХК-д 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 2019 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгалийн түүхийн музейн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Байгалийн түүхийн музейн нь “нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх улмаар Ази тивдээ тэргүүлэх зэргийн байгалийн түүхийн музей болох” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Байгалийн түүхийн музейн улсын бүртгэлийн гэрчилгээн дээр тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх

Байгалийн түүхийн музейн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Байгалийн түүхийн музейн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн багц хуулиуд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Байгалийн түүхийн музейн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Байгалийн түүхийн музейн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous санхүүгийн тооцоолох" програм хангамж ашигладаг байна.

Байгалийн түүхийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Байгалийн түүхийн музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 12 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2018 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг тооцохдоо, төсвийн байгууллага тул 2018 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзэв.

Эрсдэл бага гэж үзсэн учир, материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар сонгох нь зүйтэй гэж үзэв.

Байгалийн түүхийн музейн 2018 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 301,121.3 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 6,022.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 12 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 12 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

## **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 2.2 дахь хэсэгт заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/756 тоот тушаалаар батлагдсан салбар комисс 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн музейн нийт үзмэрийн тооллогын ажлыг хийж байна. Тооллогод нийт 8 төрлийн сан хөмрөгт хамаарагдах 9950 дэсийн 11997 ширхэг үзмэр хамрагдах ёстой бөгөөд өнөөдрийн байдлаар 8222 дэсийн 9984 ширхэг үзмэр тоологдож тооллогын ажил дэсийн тоогоор авч үзвэл 83.2 хувьтай явагдаж байна. Уг тооллого 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө дуусах бөгөөд дараагийн аудитаар холбогдох хөрөнгийн тооллогын тайлан тооцооны үр дүн санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөллийг авч үзэх шаардлагатай.

2018 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Сангийн яамны харилцах данснаас 3.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээ “улсын төсвөөс өгөх өглөг” гэсэн утгатайгаар музейн харилцах дансанд төвлөрсөн. Тус гүйлгээг санхүүгийн үр дүнгийн тайлан дээр “бусад орлого”-оор бүртгэж, засгийн газрын дотоод шилжүүлгээр төсөвт төвлөрүүлсэн дүнд тайлагнасан байна. Уг гүйлгээ нь төсөвт төвлөрүүлсэн шилжүүлсэн мөнгөнөөс буцаан авах санхүүжилтээ байгууллага татаас санхүүжилтийн авлагаар бүртгээгүй, Санхүү төрийн сангийн хэлтэстэй САГ-2019/375/СТА-ТШЗ

авлага өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс үүссэн тул хойшид Санхүү төрийн сангийн хэлтэстэй харилцах дансны үлдэгдлийн баталгаанаас гадна авлага өглөгийн тооцоо нийлэх шаардлагатайг харуулж байна.

Байгалийн түүхийн музейн барилгыг 2013 онд “ашиглах боломжгүй” хэмээн актлаад, 6 жилийн хугацаа өнгөрчээ. Бүгд Найрамдах Солонгос Улсын засгийн газраас 2016 онд буцалтгүй тусламжаар тус музейн барилгыг барьж өгөхөөр амласан боловч, тус улсад гарсан удирдлагын өөрчлөлтөөс хамааран шинэ барилгын төсөл хэрэгжих эсэх нь тодорхойгүй байна. Иймээс тус музейн барилгыг шинэчлэн барих талаар анхаарал хандуулж, арга хэмжээ авах шаардлагатай байна.

## **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Байгалийн түүхийн музейн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 21 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 325,724.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 312,518.7 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь сул орон тооны цалингийн сангаас 11,907.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 546.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлаас 50,7 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 10.0 мянган төгрөг, томилолтын зардлаас 10.7 мянган төгрөг, бусад зардлаас 8.1 мянган төгрөг үлдсэн, музейн барилгын халаалтыг хэсэгчлэн ашигласан, цэвэр усны тусгай бойлуур тавьж усны хэрэглээг бууруулсан зэргээс 673.1 мянган төгрөг хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Байгалийн түүхийн музейн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 144 мэдээллийг хугацаанд нь 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 гүйлгээ байгааг тайлант хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хэрэгжсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Байгалийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Байгалийн түүхийн музейн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<b>41,398,685.05</b>	<b>35,408,310.05</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	6,965,860.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	6,965,860.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	34,432,825.05	35,408,310.05
354	Хангамжийн материал	34,432,825.05	35,408,310.05
35410	Бичиг хэргийн материал	4,534,900.00	10,296,300.00
35420	Аж ахуйн материал	29,897,925.05	25,112,010.05
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<b>1,477,949,993.31</b>	<b>1,695,561,036.90</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,477,949,993.31	1,695,561,036.90
392	Биет хөрөнгө	1,477,949,993.31	1,589,775,576.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,669,311,200.00	2,735,880,713.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,863,781,460.77	-1,783,604,118.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,566,333.00	98,566,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-70,705,422.94	-84,661,751.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	536,613,327.32	546,187,817.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	-389,265,577.35	-423,944,072.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	251,621,132.00	251,116,632.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-155,910,192.95	-174,909,641.50
39213	Түүх соёл, музейндурсгалт зүйлс	396,032,729.00	407,936,729.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	15,788,140.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2,000,000.00	-3,049,130.06
39217	Ном	4,467,926.00	4,467,926.00
393	Биет бус хөрөнгө		105,785,460.00
39301	Програм хангамж	462,000.00	462,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-462,000.00	-462,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	-	105,785,460.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<b>1,519,348,678.36</b>	<b>1,730,969,346.95</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<b>143,200.00</b>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	143,200.00	-
413	Өглөг	143,200.00	-
4136	Бусад өглөг	143,200.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	143,200.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<b>1,519,205,478.36</b>	<b>1,730,969,346.95</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,519,205,478.36	1,730,969,346.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,280,383,754.15	1,386,169,214.15
51101	Өмч:- төрийн	1,280,383,754.15	1,386,169,214.15
512	Хуримтлагдсан үр дүн	-782,641,488.45	-841,866,295.38
51210	Өмнөх үеийн үр дүн	-782,641,488.45	-782,641,488.45
51220	Тайлант үеийн үр дүн	-	-59,224,806.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,021,463,212.66	1,186,666,428.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<b>1,519,348,678.36</b>	<b>1,730,969,346.95</b>

### 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	<b>320,881,649.75</b>	<b>352,016,775.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>20,083,889.75</b>	<b>20,992,275.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	13,473,889.75	20,992,275.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,473,889.75	20,877,575.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	43,885.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,473,889.75	19,833,690.00
120009	Бусад орлого	-	114,700.00
122	Тусламжийн орлого	6,610,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	960,000.00	-
122002	Хандив тусламж /гадаад/	5,650,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>300,797,760.00</b>	<b>331,024,500.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	300,797,760.00	324,724,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	300,797,760.00	324,724,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,300,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<b>434,751,943.55</b>	<b>412,374,981.93</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<b>434,751,943.55</b>	<b>412,374,981.93</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>411,374,893.28</b>	<b>394,607,983.11</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219,426,626.17	217,683,245.16
210101	Үндсэн цалин	201,843,326.17	205,120,145.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,583,300.00	11,829,000.00
210104	Урамшуулал	-	734,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,921,669.42	26,308,566.39
210201	Тэтгэврийн даатгал	15,620,909.42	17,526,733.21
210202	Тэтгэмжийн даатгал	2,325,190.00	2,159,466.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,860,272.00	1,751,572.80
210204	Ажилгүйдлийн даатгал	464,918.00	437,893.38
210205	Эрүүл мэндийн даатгал	4,650,380.00	4,432,900.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,089,042.81	7,617,793.93
210301	Гэрэл, цахилгаан	3,101,876.00	3,311,245.00
210302	Түлш, халаалт	3,437,730.47	3,635,253.20
210303	Цэвэр, бохир ус	549,436.34	671,295.73
2104	Хангамж, бараа материалын зардал	20,913,747.73	16,696,322.10
210401	Бичиг хэрэг	733,210.00	1,056,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,782,400.00	1,782,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,656,247.33	2,575,156.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	880,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,549,480.00	2,128,200.00
210408	Бараа материал акталсны зардал	13,792,410.40	8,273,966.00
2105	Нормативт зардал	787,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	787,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,128,200.00	2,000,000.00

Байгалийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	1,128,200.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,329,900.00	9,955,290.00
210702	Дотоод албан томилолт	4,329,900.00	9,955,290.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,609,754.00	21,176,643.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,211,740.00	16,169,079.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,178,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,329,930.00	1,271,180.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	266,100.00	542,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	1,149,984.00	1,149,984.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	430,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,168,953.15	93,170,121.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	410,800.00	2,084,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	120,758,153.15	88,273,161.93
210904	Найдваргүй авлагын алдагдал	-	2,812,860.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>23,377,050.27</b>	<b>17,766,998.82</b>
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	14,377,050.27	17,766,998.82
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	14,377,050.27	17,766,998.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b><u>-113,870,293.80</u></b>	<b><u>-60,358,206.93</u></b>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	<b>1,133,400.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	1,133,400.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	<b>1,133,400.00</b>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b><u>-113,870,293.80</u></b>	<b><u>-59,224,806.93</u></b>

### 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>304,402,980.00</b>	<b>336,585,733.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,457,000.00	5,561,233.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,457,000.00	5,561,233.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,457,000.00	5,557,733.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,457,000.00	5,513,848.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	43,885.00
120009	Бусад орлого	-	3,500.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>300,945,980.00</b>	<b>331,024,500.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	300,797,760.00	324,724,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	300,797,760.00	324,724,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,300,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	148,220.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	148,220.00	-
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>303,523,180.00</b>	<b>323,128,893.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	303,523,180.00	323,128,893.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280,146,129.73	305,361,894.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	219,574,846.17	217,863,093.16
210101	Үндсэн цалин	201,991,546.17	205,299,993.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,583,300.00	11,829,000.00
210104	Урамшуулал	-	734,100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,921,669.42	26,308,566.39
210201	Тэтгэврийн даатгал	15,700,969.42	22,068,545.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,305,200.00	1,034,268.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,844,200.00	851,414.70
210204	Ажилгүйдлийн даатгал	461,000.00	212,853.90
210205	Эрүүл мэндийн даатгал	4,610,300.00	2,141,483.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,089,042.81	7,617,793.93
210301	Гэрэл, цахилгаан	3,101,876.00	3,311,245.00
210302	Түлш, халаалт	3,437,730.47	3,635,253.20
210303	Цэвэр, бохир ус	549,436.34	671,295.73
2104	Хангамж, бараа материалын зардал	7,561,737.33	9,174,545.10
210401	Бичиг хэрэг	1,046,710.00	1,022,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,782,400.00	1,782,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,656,247.33	2,575,156.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	880,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,676,380.00	2,914,989.00
2105	Нормативт зардал	2,303,000.00	2,389,986.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,303,000.00	2,389,986.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,128,200.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	1,128,200.00	2,000,000.00
2107	Томилот, зочны зардал	4,329,900.00	9,955,290.00

Байгалийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	4,329,900.00	9,955,290.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,571,934.00	26,918,519.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,153,920.00	21,910,955.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,178,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,329,930.00	1,271,180.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	266,100.00	542,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	1,149,984.00	1,149,984.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	450,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	665,800.00	3,134,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	665,800.00	3,134,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,377,050.27	17,766,998.82
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	14,377,050.27	17,766,998.82
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	14,377,050.27	17,766,998.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,000,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<b><u>879,800.00</u></b>	<b><u>13,456,840.00</u></b>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<b>879,800.00</b>	<b>13,456,840.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	879,800.00	13,456,840.00
2200	Дотоод эх үүсвэрээр	879,800.00	13,456,840.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	879,800.00	13,456,840.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<b><u>-879,800.00</u></b>	<b><u>-13,456,840.00</u></b>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
14	Бусад эх үүсвэр	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,280,383,754.15</b>	<b>1,021,463,212.66</b>	<b>-779,098,367.37</b>	<b>1,522,748,599.44</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	110,327,172.72	110,327,172.72
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,280,383,754.15	1,021,463,212.66	-668,771,194.65	1,633,075,772.16
Тайлант үеийн үр дүн	-	-	-113,870,293.80	-113,870,293.80
2017 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,280,383,754.15</b>	<b>1,021,463,212.66</b>	<b>-782,641,488.45</b>	<b>1,519,205,478.36</b>
2018 оны 01 сарын 01-нээрх үлдэгдэл	<b>1,280,383,754.15</b>	<b>1,021,463,212.66</b>	<b>-782,641,488.45</b>	<b>1,519,205,478.36</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,280,383,754.15	1,021,463,212.66	-782,641,488.45	1,519,205,478.36
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	165,203,215.52	-	165,203,215.52
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	105,785,460.00	-	-	105,785,460.00
Тайлант үеийн үр дүн	-	-	-59,224,806.93	-59,224,806.93
2018 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,386,169,214.15</b>	<b>1,186,666,428.18</b>	<b>-841,866,295.38</b>	<b>1,730,969,346.95</b>

### 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>325,724,500.00</b>	<b>312,518,734.18</b>	<b>13,205,765.82</b>	<b>95.95%</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	325,724,500.00	312,518,734.18	13,205,765.82	95.95%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,724,500.00	312,518,734.18	13,205,765.82	95.95%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	226,352,600.00	217,863,093.16	8,489,506.84	96.25%
Үндсэн цалин	213,789,500.00	205,299,993.16	8,489,506.84	96.03%
Унаа хоолны хөнгөлөлт	11,829,000.00	11,829,000.00	-	100.00%
Урамшуулал	734,100.00	734,100.00	-	100.00%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,726,200.00	26,308,566.39	3,417,633.61	88.50%
Тэтгэврийн даатгал	20,145,700.00	22,068,545.90	-1,922,845.90	109.54%
Тэтгэмжийн даатгал	2,395,100.00	1,034,268.20	1,360,831.80	43.18%
ҮОМШӨ-ний даатгал	1,916,100.00	851,414.70	1,064,685.30	44.43%
Ажилгүйдлийн даатгал	479,000.00	212,853.90	266,146.10	44.44%
Эрүүл мэндийн даатгал	4,790,300.00	2,141,483.69	2,648,816.31	44.70%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,290,900.00	7,617,793.93	673,106.07	91.88%
Гэрэл, цахилгаан	4,468,900.00	3,311,245.00	1,157,655.00	74.10%
Түлш, халаалт	2,131,200.00	3,635,253.20	-1,504,053.20	170.57%
Цэвэр, бохир ус	1,690,800.00	671,295.73	1,019,504.27	39.70%
Хангамж, бараа материалын зардал	9,225,200.00	9,174,545.10	50,654.90	99.45%
Бичиг хэрэг	1,279,000.00	1,022,000.00	257,000.00	79.91%
Тээвэр, шатахуун	1,782,400.00	1,782,400.00	-	100.00%
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,043,800.00	2,575,156.10	468,643.90	84.60%
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,080,000.00	880,000.00	200,000.00	81.48%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,040,000.00	2,914,989.00	-874,989.00	142.89%
Нормативт зардал	2,400,000.00	2,389,986.60	10,013.40	99.58%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	2,389,986.60	10,013.40	99.58%
Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	6,000,000.00	-	100.00%
Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00	-	100.00%
Томилолт, зочны зардал	9,966,000.00	9,955,290.00	10,710.00	99.89%
Дотоод албан томилолт	9,966,000.00	9,955,290.00	10,710.00	99.89%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,021,500.00	29,475,459.00	546,041.00	98.18%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,481,400.00	24,467,895.00	13,505.00	99.94%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,200,000.00	2,000,000.00	200,000.00	90.91%
Даатгалын үйлчилгээ	1,511,000.00	1,271,180.00	239,820.00	84.13%

Байгалийн түүхийн музейн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тээврийн хэрэгслийн татвар	635,100.00	542,400.00	92,700.00	85.40%
Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	-	100.00%
Газрын төлбөр	1,150,000.00	1,149,984.00	16.00	100.00%
Бараа үйлчилгээний бусад зардал	3,742,100.00	3,734,000.00	8,100.00	99.78%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,742,100.00	3,734,000.00	8,100.00	99.78%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>325,724,500.00</b>	<b>312,518,734.18</b>	<b>13,205,765.82</b>	<b>95.95%</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>324,724,500.00</b>	<b>306,957,501.18</b>	<b>17,766,998.82</b>	<b>94.53%</b>
Улсын төсвөөс санхүүжих	324,724,500.00	306,957,501.18	17,766,998.82	94.53%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,000,000.00</b>	<b>5,561,233.00</b>	<b>-4,561,233.00</b>	<b>556.12%</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	5,517,348.00	-4,517,348.00	551.73%
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	43,885.00	-43,885.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>100.00%</b>
Төсвийн байгууллага	1	1	-	100.00%
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>42</b>	<b>35</b>	<b>7</b>	<b>83.33%</b>
Удирдах ажилтан	1	1.00	-	100.00%
Гүйцэтгэх ажилтан	29	27.00	2	93.10%
Үйлчлэх ажилтан	12	7.00	5	58.33%
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>42</b>	<b>35.00</b>	<b>7</b>	<b>83.33%</b>
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	19	19	-	100.00%
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	16	-4	133.33%
Гэрээт ажилтан	11	0	11	

### 3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<b>6,300,000.00</b>	<b>6,300,000.00</b>	-	<b>100%</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,300,000.00	6,300,000.00	-	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,300,000.00	6,300,000.00	-	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,300,000.00	6,300,000.00	-	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,300,000.00	6,300,000.00	-	100%
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	<b>6,300,000.00</b>	<b>6,300,000.00</b>	-	<b>100%</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,300,000.00	6,300,000.00	-	100%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,300,000.00	6,300,000.00	-	100%
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=(II-I))	-	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

